



НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 2-10

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 11-41

- 1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа 2022.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 14-22
- 2. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны тайлан сонсох* 22-25
- 3. Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны экспортын тухай” тавьсан асуулгын хариуг сонсох* 25-37
- 4. Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах.* 37-41

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
01 дүгээр сарын 13-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Ц.Анандбазар, С.Ганбаатар, Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ж.Батжаргал, Б.Баярсайхан, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл, Ч.Ундрэм;

Чөлөөтэй: Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан;

Тасалсан: Э.Бат-Амгалан;

Хоцорсон: Э.Батиугар-49минут, Б.Бейсен-1 цаг 12 минут, Д.Ганбат-26 минут, Н.Ганибал-17 минут, Х.Нямбаатар-11 минут, Г.Тэмүүлэн-1 цаг 37 минут, Д.Цогтбаатар-39 минут, О.Цогтгэрэл-12 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийн мэндчилгээ болон төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэв.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа 2022.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Г.Эрдэнэбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 11
Бүгд: 51
78.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны тайлан сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооноос гаргасан тайланг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороо татан буугдсаныг мэдэгдэв./11:02/

Уг асуудлыг 11 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны экспортын тухай” тавьсан асуулгын хариуг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Санчирдорж, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Монголжингоо нар байлцав.

Асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 06 минутаас хуралдааныг даргалав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Н.Ганибал, Ш.Адьяаа нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны экспортын тухай” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг хэлэлцлээ.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:48/

2.Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:48/

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:48/

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:49/

5.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:49/

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:49/

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:49/

8.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:49/

9.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

10.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

11.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

12.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

13.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

14.Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:50/

15.Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:51/

16.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:51/

17.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:51/

18.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:51/

19.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:51/

20.““Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

22.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

23.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

24.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

25.Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:52/

26.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:53/

27.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:53/

28.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:53/

29.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:53/

30.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:53/

31.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:54/

32.Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:54/

33.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:54/

34.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:54/

35.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:54/

36.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

37.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

38.Өрийн удирдлагын тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болгох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

39.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

40.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

41.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

42.Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

43.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

44.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

45.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

46.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

47.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

48.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

49.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

50.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

51.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

52.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

53. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

54. “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

55. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

56. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, 76 гишүүнээс 60 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтган мэндчилье. Танхимд мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийн мэндчилгээг танхимд өргөн дэвшүүлье. Өнөөдөр ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсан өдөр. Бас энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

1 дүгээр сарын 9-нд Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням мэндэлсэн байна. Энийг гишүүд алга байна. Гишүүдийг ирэхээр. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Хэлэлцэх асуудлыг танилцуулья. Өнөөдөр 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа нарын өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал

боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны тайланг сонсоно.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны экспортын тухай” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-т заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 5 цаг, 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн байна. Уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг гэсэн байна.

Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдэд Үндсэн хууль батлагдсан, ардчилсан Үндсэн хууль батлагдсан өдрийн мэндийг хүргэе.

Би яг өнөөдөр энэ Үндсэн хуультай холбоотой 1 асуудлыг заавал хэлэх хэрэгтэй гэж бодож байна. Өчигдөр манайхан энэ Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг ярьсан. Одоо эцсийн хэлэлцүүлэгт шилжиж байгаа. Тэгээд энэ дээр та нар нэг юмыг анхаараад өгөөч гэж би та бүхнээс хүсэж байгаа юм. Энэ хуулийн 7.4 дээр хөрөнгө

оруулалтын төрөлжсөн банкны барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл гээд эхэлж байгаа юм. Тэгэхээр би одоо юунд санаа зовж байна вэ гэхээр энэ Хөрөнгө оруулалтын банк бол ер нь ихэвчлэн гадаадын хөрөнгө оруулалттай байх болов уу.

Хоёрдугаарт, энэ манайхны гар дээр байгаа лицензүүд бүгдээрээ энэ банкны барьцаанд очих болов уу. Энэ агуулгаараа Монголын ард түмний газрын баялаг аль нэгэн хөрөнгө оруулалтын нэртэй банкны юм болж хувирах болов уу. Та нар энийгээ сайн үзэж, сайн ярьсан юм болов уу, яасан юм бол?

Тэгээд би Үндсэн хууль батлагдсан өдөр бол би бол юу гэж боддог юм гэхээр ер нь энэ лиценз гэдэг юмыг банканд барьцаалж болохгүй. Ер нь энэ шинэ ардчилсан Үндсэн хууль 30 гаруй жил явахад Монгол Улсын эдийн засагт олигтой өөрчлөлт гарахгүй байгаа чинь манай энэ Үндсэн хуулийн заалт хэрэгжихгүй байгаа явдал юм. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд бол Монгол Улсад газар түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэсэн. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гэсэн.

Тэгсэн одоо юу болчихоод байна вэ гэхээр лиценз гэдэг юмыг одоо энэ манай гишүүд бас хуулийнхан их анхаармаар байна. Лицензийн банканд барьцаална гэдэг чинь бараг амьдрал дээрээ лиценз авна гэдэг бол тэр байгалийн баялгийг өмчлөгч болж хувирчихсан юм шиг болчихоод байгаа юм. Угтаа бол энэ бол ард түмний өмч. Лиценз авсан ч гэсэн ард түмний өмч хэвээр үлдэнэ. Ганцхан ашиглах эрх л бол тэр лицензээр дамжиж очиж байгаа гэж би ойлгож байгаа юм.

Тэгээд энэ Жавхлан энэ Жавхлан санаачилсан юм байна лээ. Тэгэхээр та нар маань ер нь бантан хутгав аа. Монголын баялаг ард түмний баялаг одоо ингээд цөөхөн хүний гарт очих 1 банкны нэр, гаднын банкны гарт очих за ингээд юу ч үгүй хоцрох ийм юм руу явах вий дээ. Та нар энэ дээрээ дахиж яриарай гэж би хүсэж байна.

Уг нь бол ийм логиктой байхгүй юу. Миний сая уншаад байгаа Үндсэн хуулийн заалтын дагуу органик хуулиудад өөрчлөлт орж ирэх ёстой. Тухайлах юм бол Ашигт малтмалын тухай хуульд бид нар саяын миний хэлж байгаа санааг сайн тодотгоод энэ өмчлөх эрх юм уу, эзэмших эрх юм уу, ашиглах эрх юм уу гэдгийг тодотгож Ашигт малтмалынхаа хуульд хийж өгөх ёстой.

Гэтэл одоо энэ Жавхлангийн санаачилсан хуулийг яаруу сандруу оруулж ирж байгаад би бас их сэжиглэж байна. Энэ Үндсэн хууль буюу тэр органик хууль, Ашигт малтмалын тухай хуульд энэ харилцааг зохицуулаагүй мөртөө, засаж янзлаагүй мөртөө хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл. Энэ юу гэсэн үг вэ гэхлээр хөрөнгө оруулалтын банк бол ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн лицензийг бол барьцаалах юм байна. Би Энийг бараг ер нь захиалгатай хийж байгаа үйлдэл гэж харж байна шүү.

Тийм учраас энэ Үндсэн хууль, ардчилсан Үндсэн хууль батлагдсан өдөр гээд байдаг энэ өдөр хэдүүлээ Монголын ард түмэнд өөрсдөө байгалийнхаа баялгийн эзэн байх энэ боломжийг нь ингэж хулгайлж болохгүй шүү. Энэ бол хуулийн хулгай шүү. Би дахин анхааруулаад хэлчихье. Тэгээд та нар маань сайн тунгааж бодоорой. Эцсийн хэлэлцүүлэгт шилжчихсэн хууль шүү. Эцсийн хэлэлцүүлэгт шилжчихсэн. Одоо ингээд нэг цохиод гарна шүү. Баярлалаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлэхээ бичгээр ирүүлсэн.

Б.Пүрэвдорж: Хуурамч шатахууны хуулийг 2 жилийн өмнө 2 жилийн турш ярьж байж хууль батлуулж энийг зогсоосон. Гэтэл энэ хуурамч шатахууны хуулийг 1 Их Хурлын гишүүн дизелийн түлш холих зорилгоор, нөгөөдөх нь Засгийн газар 92 холих зорилгоор оруулж ирлээ.

Хуурамч шатахуун гэж юу байдаг юм бэ гэдгийг та нарт хэлж өгье. Том нөгөө цахилгаан юуны нефтийн агуулахууд байгаа юм. Агуулах 75 хувьд нь оригинал дизелийн түлш хийнэ, 25 хувьд нь керосин натригтай холино, бүтэн болгоно. Доор нь цахилгаанаар, сэнсээр эргүүлнэ. Тэгэнгүүт хольсон болно. Тэгэнгүүт тэрнийгээ Улаанбаатар хотын клонк дээр зөөж аваачна. Зөөж аваачихаар хүнд элемент нь доошоо унаад, хөнгөн элемент нь дээшээ гарна. Хөнгөн элементийг хэрэглэсэн цагаан утаа хаяна, хүнд элементийг хэрэглэсэн нь хар утаа хаяна. Ингээд машинууд эвдэрнэ. Бензин машин карбиратир нь 2 жил болоод эвдэрнэ, дизель машины аппаратур 1 жил болоод эвдэрдэг. Монголчуудын бүх машин эвдэрч байгаа. Машин эвдэрснээс болж хөдөө хөлдөж үхсэн, нас барсан ийм тохиолдлууд маш их.

Дээрээс нь та бүхэн санаж байгаа бол 2 жилийн өмнө энэ Улаанбаатар хотын гудамжны шонгийн 50 метрээс дооших нь хав хар байдаг байсан. Тэр яадаг вэ гэхлээр нөгөө хүнд металл хэрэглэсэн автобуснууд тэрийг хэрэглээд тэр нь хар болсон. Одоо тэгсэн чинь Улаанбаатар хотын шонгууд ямар ч тийм хав хар юм байхгүй байгаа. Магадгүй над шиг хүн бол тэр хүнд металлыг амьсгалахгүй. Та нарын хүүхдүүд тэр хөтлөөд явж байгаа замын хажуугаар явж байгаа хүүхдүүд амьсгална. Урагт нөлөөлнө. Монголчуудын ген өөрчлөгдөнө. Тэгээд энэнээс зөвхөн нэгхэн, хоёрхон,

гуравхан компани 100 тэрбум төгрөгийн ашиг олдог. Тэр нь Монгол Ардын намын компаниуд тэд нарыгаа санхүүжүүлдэг, тэндээсээ авлигал авдаг. Ийм хуулийг оруулж ирж байна. Энэ хуулийг та нар Их Хурлаар давуулна гонжийнжоо мэд ээ. 2 жил үзэж байж энийг батлуулсан хуулийг Монголчуудын генийг өөрчлөх, Монголчуудын энэ үр удмыг таслах ийм хууль оруулж байгаа юм. Дэлхийд даяараа Евро 5-ыг хэрэглэж байхад Монголчууд тээр тэр дундад зууны юмыг хэрэглээд явах нь байна шүү дээ.

Үүний жишээ, шалтгаан нь болохоор шатахууны үнэ өссөн гэж байна. Өнгөрсөн он 12 сард Уразны нефтийн үнэ barrel нь 80 доллар байж байгаад 1 сарын 1-нээс олон улсын хоригт ороод 40 доллар болчихсон байгаа. Шатахуун хэлэлцээрийн үр дүнд 1 дахин буурах ийм боломж байна. Уул уурхай, эрчим хүч, уул уурхайн сайд нь тэр Орос руу яв л даа. Гадаад хэргийн сайд нь Орос руу яв л даа. Өндөр байхад нь 2 жилийн өндөр үнэтэй гэрээ хийчихсэн. Тэр гэрээгээ та нар цуцал л даа. Ингэж Монголчуудыг хохироож хэдхэн хүн баяжиж, энэ хуулийг батлуулна гэвэл эндүүрэл шүү. Хахуулийн чинь мөнгө хэтрээд байгаа бол энэ нүүрсний хулгайнаас, энэ төмөр замын тээврийн хулгайнаас илүү хулгай шүү. Мөнгө чинь хэнд очсон нь мөртэй байгаа шүү. Шуналын чинь тэр хүүдий Монголчуудын энэ гуниг харуусал дээр чиний хоол болохгүй шүү. Гишүүд энэ дээр анхааралтай байгаарай. Та бидний ихэнх нь 2021 онд энэ хуулийг баталсан ийм хууль. Зарим нэг шуналтнууд дахиж оруулж ирж байна.

Г.Занданшатар: Энэ Ганбаатар сайд хаачив? Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга Засгийн газраас өргөн барьсан тэр 92-ын татварыг л чөлөөлөхтэй холбоотой хууль байгаа шүү дээ. Тэр дотор нь тэгээд юм байгаа бол хэлэлцээд шийдвэрлэх биз.

Энэ Алтанхуяг гишүүний хэлж байгаа санал бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр, өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, ард иргэдэд, түмэнд тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасан байгаа. Энийг эрх зүйн үндсийг хуулиар тогтоохын тулд энэ Ашигт малтмалын хууль, Үндэсний баялгийн сангийн хуулиудыг өргөн барьж хэлэлцүүлэх шаардлагатай. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд нар энийг анхаарч энэ Үндэсний баялгийн сангийн хууль, Ашигт малтмалын хуулиа яаралтай шинэчлэх хэрэгтэй байгаа юм. Ингээд хэлэлцэх асуудалд орно. Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа танилцуулна.

Ш.Адьшаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, эдийн засгаа сэргээх, эрчимжүүлэх хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийн болон аж ахуйн нэгжүүдийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Монгол Улсын Хөгжлийн банк, Монгол Улсын хөгжлийн мега төслүүдэд хөрөнгө оруулах чиглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкныг байгуулсан билээ.

Гэвч энэхүү хөрөнгө оруулалтууд зорилтот салбартаа, зорилтот бүлэгтээ тэр бүр хүрэхгүйгээр улс төрд нөлөө бүхий албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлоор завшсан зээл олгоход баримтлах хууль тогтоомжийг зөрчин нөлөөлөх, өөрийн хамаарал бүхий хуулийн этгээдүүд олгуулсны улмаас энэ хэрэгт улс төрийн болон эрүүгийн хариуцлага хүлээсэн явдал удаа дараа гараад байна.

Энэ нь улс төрд нөлөө бүхий этгээдүүд шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад төрөөс баталгаа гаргасан хөнгөлөлттэй нөхцөлөөр их хэмжээний зээл, хөрөнгө оруулалт бүхий бий болгож, тэдгээрийг эргээд өөрсдөө өөрийн хамаарал бүхий хуулийн этгээдүүдээр дамжуулан хуваан авч байгаа маш ноцтой сонирхлын зөрчил юм.

Үүний улмаас Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийн хэмжээ өсөж, банкны эрсдэл давах чадвар үгүй болсон. Эдгээр хууль бус асуудал бол авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой гэж олон нийтийн зүгээс хардлага нэмэгдэж, төрд итгэх ард иргэдийн итгэл буурсаар байна.

Иймд Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хангахад төрд итгэх итгэлийг

иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, нийтийн болон нийтийн албаны үйл ажиллагааг хувийн ашиг сонирхлын урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн өндөр албан тушаалтан нь төрөөс баталгаа гаргасан зээл, тусламжаас авах хуулийн зохицуулалт, авахыг хориглох хуулийн зохицуулалтыг санаачилж оруулж ирлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан бөгөөд олон нийтийн зүгээс тусгайлан санал ирүүлээгүй болно.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адьшаагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч, төрийн өндөр албан тушаалтан тэдгээрийн хамаарал бүхий этгээд эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор төрөөс санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч төрөөс үзүүлэх аливаа дэмжлэг, тусламж авахыг хориглох зохицуулалтыг хуулийн төсөлд тусган боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Нямбаатар төрийн өндөр албан тушаалтан тодорхой хориглолт, хязгаарлалт тогтоох зохицуулалтыг тусгаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу анхны хэлэлцүүлгийн үед хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төрийн өндөр албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээд төрөөс үзүүлэх аливаа дэмжлэг, тусламж авахыг хориглосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байх бөгөөд хамаарал бүхий этгээд гэдэг өргөн утгатай ойлголт байдаг. Хэрэв хамаарал бүхий этгээд нь төрөөс ямар нэг дэмжлэг, тусламж авсан тохиолдолд төрийн өндөр албан тушаалтанд нөлөөлөх хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат хууль батлагдсанаар гарах үр дагаврын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр уг хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт олгох тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Илтгэгчид баярлалаа. Ажлын хэсгийн гишүүнийг танилцуулъя. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Ганбатын Эрдэнэбат.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Сүхбаатар: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэж, Үндсэн хуулийн өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр тохиож байгаа учраас бид нар бас Үндсэн хуулийнхаа талаар бас танин мэдэх, тэрийгээ зөв хэрэглэх, тууштай мөрдөх талаар бас анхаарч ажиллаж байх ёстой. Мэдэгтүн, сахигтун гэж дууссан байдаг.

Энэ өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд, 31 жилийн хугацаанд бол бид нар бас мэдэх тал дээрээ бол дутуу бас ажилласан юм бий. Зөв хэрэглэх тал дээр асуудал гараад байдаг. Тууштай мөрдөх тал дээр шүүмжлэлтэй асуудлууд үүсдэг. Нэг бол Үндсэн хуулиа үгүйсгэдэг, нэг бол Үндсэн хуулийнхаа юмыг огт засаж сайжруулах талаар бас байх ёсгүй гэдэг ийм асуудлууд яригдаж ирсэн.

Ер нь бол яах вэ нэг зүйлээс болгоомжлох ёстой. Үндсэн хууль руу хамаг алдаа, дутагдлаа чихэж, Үндсэн хуулийг үгүйсгэж, Үндсэн хуулийн үгүйсгэл гэдэг бол хамгийн аюултай. Төр улсын тусгаар тогтнол одоо энэ оршин тогтнох хууль ёсны байдлыг үгүйсгэх аюул занал үүсдэг. Тэгэхээр энэ дээр бол бид бас анхаарч байх ёстой. Одоо энэ Үндсэн хуулийг үгүйсгэж байгаа улсуудын хамгийн гол ярьдаг юм бол энэ төр болохгүй байна, төрд байгаа хүмүүс бол болохгүй байна гэж ярихдаа Үндсэн хуультай холбож яриад байдаг юм.

Тэгэхээр бас энэ дээр бол энэ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэж байгаа. Энэ хуулийг 10 жилийн өмнө Тэмүүжин гишүүн бид бид нар санаачилж байсан юм. Би Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо дарга байхдаа нэлээн асуудал болж, зарим хүмүүсийн эсэргүүцлийг даван туулж, энэ хуулийг батлуулж байсан. Энэ хуульд бол 2 чухал юм байдаг.

Нэг нь төрийн алба гэдэг үгийг нийтийн алба болгож анх удаа хуульд нь хэрэглэсэн байдаг. Өргөн утгаараа. Ер нь бол төрийн алба гэдэг үг бол Германд гэдэг юм уу, үзэх юм бол ийм нэр томъёо бол байхгүй. Оросын Холбооны Улс, Зөвлөлт Холбоот Улсын үеэс эхлээд бид нар төрийн алба буюу төрд өөрт нь ашиг сонирхол байдаг мэтээр ярьж ирсэн. Төрийн ашиг

сонирхол та чинь юу яриад байгаа юм төрийн ашиг сонирхлыг анхаарах ёстой гэж.

Орчин цагт бол нийтийн ашиг сонирхол гэж байдаг. Төрд өөрт нь ашиг сонирхол гэж бол байх ёсгүй. Төрийн ашиг сонирхол гэж бид нарын ойлгоод, буруу бичээд, зөв ойлгоод байдаг юмыг бид нийтийн ашиг сонирхол гэж зөв ойлгох ёстой. Төрд өөрт нь алба байхгүй, нийтэд үйлчилдэг алба байгаа.

Харин нийтийн алба дотор нь Засгийн газрын тэр хариуцан ажилладаг алба, дипломат буюу тусгай алба, орон нутгийн алба гэж ингэж хуваагдаж явдаг. Тэгэхээр төрийн ялзрал, Үндсэн хуулийн мөрдөхгүй байх хамгийн гол юм бол ашиг сонирхлын зөрчилд идэгдэх явдал байдаг. Би өнөөдөр энэ Их Хурлын гишүүн Адьшаа гишүүний оруулж ирж байгаа энэ зүйлийг бол зөв, зүйтэй гэж үзэж байгаа.

Ер нь төрийн эрэг боолт, өөртөө тавигдах шаардлагууд бол чангарч байгаа. Энд сууж байгаа Сүхбаатар гишүүн ч гэсэн одоо энд өөрөө хамгийн сайн ажил хийж байгаа гэвэл орчин цагт бид юу вэ гэхээр энэ Сүхбаатар гэдэг нөхрийг гэдэг юм уу, энд байгаа Их Хурлын гишүүд бид өөрсдийгөө хязгаарлахаас эхэлж байгаа юм. Бусдад шаардлага тавихын тулд төрд байгаа эрх баригчид өөртөө тавих шаардлагаа өндөржүүлэх ёстой. Энэ цаг үед бол манай энэ Их Хурлын үед бол энэ ажил бол маш сайн хийгдэж байгаа гэж үзэж байгаа. Их Хурлын гишүүн Адьшаагийн энэ оруулж ирж байгаа зүйл бол зөв. Харин 1 асуулт байна.

Төрийн өндөр албан тушаалтан түүний хамаарал бүхий этгээд гэхихээр Адьшаа гишүүнээ энэ чинь бас явцуу хүрээнд ороод явчхаж байгаа. Төрийн өндөр албан тушаалтан гээд Дээд шүүхийн тамгын дарга гээд явж байхад нөгөө улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг чинь бүр

өргөн утгаар томьёолчихсон байдаг байхгүй юу. Явж явж манай энэ ялзрал чинь улс төрд нөлөө бүхий этгээдүүдтэй холбоотой. Мөнгө угааж байна. Олон улсын хэмжээнд ч гэсэн энийг ярьдаг. Тэгэхээр та улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг энэ өргөн утгаар нь авч үзэх тал дээр анхаарч үзсэн үү, үгүй юу? Энэ дээр бол танилцуулга дээр төрийн өндөр албан тушаалтны хамаарал бүхий этгээд гээд явчхаж. Тэгээд энэ манай Улсын Их Хурлын гол юм бол ёс зүйн асуудал гэж яриад байгаа шүү дээ. Бид ёс зүйн өндөрлөг дээрээ байж байж хүлээн зөвшөөрөгдөнө.

Тэгэхээр энэ ашиг сонирхлын зөрчлийн хуулийг цаашид Засгийн газар ч гэсэн сайжруулахаар саналаа оруулж ирэх гэж байгаа юм. Хамтатгаад.../минут дуусав./

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн хариулья.

Ш.Адьшаа: Сүхбаатар гишүүний асуултад хариулья. Энэ Сүхбаатар гишүүний хэлсэн саналыг бол хүлээж авлаа. Тэр бол яах вэ, төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн хамаарал бүхий этгээдүүд гэдгийг хэлэлцүүлгийн явцад бас хэлэлцээд явах боломжтой гэж үзэж байна. Монгол Улсын Засгийн газраас бас энэ хуультай адилхан ийм зохицуулалт, асуудлыг өргөн барьж, оруулж ирж байгаа. Тэгэхдээ энэ хамтатгаад хэлэлцээд явна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Г.Занданшатар: Тийм, энэ Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүний хэлсэн тэр Үндсэн хууль Мэдэгтүн, сахигтун гэж дуусаж байгаа. Тэгээд мэдэх гэдэг бол Үндсэн хуулийн мэдэж, зүгээр бичиг үсэг тайлагдсан төдийгөөр унших төдий асуудал биш.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, үзэл санаа, философийг мэдэж, ойлгож, хэрэгжүүлж, хуульд тусгаж нэг мөр

хэрэгжүүлэх асуудал бол өнгөрсөн 30 жил хангалтгүй юм байна, хийгдсэн байна гэж Үндсэн хууль судлаач Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар номд дурдсан байна лээ.

Тийм учраас хууль тогтоогчдын хувьд бол энийг бас их анхаарах ёстой ийм зайлшгүй шаардлага гэж бас үзэх нь зүйтэй байх. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр бид бол Ашиг сонирхлын зөрчлийн хуулиа Засгийн газар нь ч одоо чангатгана, Монгол улсын Ерөнхий сайд энэ асуудал дээр бол байр сууриа хэлж байгаа юм.

Ер нь ёс зүйн өндөрлөгөө эрх баригчид чинь авч явна. Тэгж байж цаашаа биднийг хүлээн зөвшөөрч, итгэж засаглана гэж байгаа. Тийм учраас өөрийнхөө одоо эрх барьж байгаа улс төрийн хүчиндээ ч гэсэн хатуу шаардлага тавьж байгаа. Тэгээд Адьшаа гишүүний энэ оруулаад ирснийг сая Адьшаа гишүүн хамтатгаад явах боломжтой гэж байна. Ингээд бүтээлчээр ажиллацгаая.

Тэгэхдээ энэ ашиг сонирхлын зөрчлийн хууль дээр бүгдийг овоолж хийгээд юм явахгүй. Намын тухай хууль одоо энэ хаврын чуулганд яаралтай оруулж ирэх хэрэгтэй байна Их Хурлын дарга аа, Сонгуулийн хууль байна. Манай төрд болж болж бүтэхгүй байгаа улсууд чинь сонгуулиар, намаар дамжиж байна гэж яриад байна шүү дээ хүмүүс. Энэ шүүлтүүр ажиллахгүй байна. Тавигдах шаардлага нь энэ нам, сонгуулийн системээр л дамжиж байгаа байхгүй юу.

Тэрнээс биш Үндсэн хууль нь муудаад л юм уу, төр нь ингээд л өөрөө болохгүй болчихоод байгаа гэж ярих нь буруу байхгүй юу. Хаана юм шахаж нийлүүлээд байна, тэр суваг нь нам,

сонгуулийн тогтолцоо шүү. Энийгээ.../минут дуусав./

Г.Занданшатар: Энэ хуультай шууд холбогдохгүй асуудал байна. Адьшаа гишүүн хариулахгүй байх. Тогмидын Доржханд гишүүн хууль санаачлагчаас болон Байнгын хорооны санал, дүгнэлтээр.

Т.Доржханд: Баярлалаа. Би энэ зарчмыг нь бол дэмжиж байна. Тэгээд 2 асуулт байна. Энэ өмнө нь болохлоороо тендер шалгаруулалтад орох, ямар нэгэн баталгаа гаргах асуудлыг бол хориглосон ийм заалт байсан байна шүү дээ тийм ээ. Гэтэл одоо болохлоор нэмээд эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор төрөөс санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, төрөөс үзүүлэх аливаа дэмжлэг, тусламж гэдэг зүйлийг нэмж байна гэж ойлгож байна.

Тэгэхлээр энэ хүрээнд нөгөө түрүүн ч бас хууль санаачлагч танилцуулгадаа хэллээ. Энэ Жижиг, дунд үйлдвэрийн сан, Хөгжлийн банк гэх мэтчилэнгийн эдгээр сангуудаас л мөнгө авахыг нь хориглоё л гэсэн агуулгаар орж ирж байгаа юм байна гэж би ойлгож байна. Тийм үү. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор яг та одоо санаачлагчийн үүднээс судалгаа байгаа байлгүй дээ. Яг ямар төрийн албан тушаалтнууд, хамаарал бүхий этгээдүүд яг ямар хэмжээний санхүүжилтийг авчхаад байгаа юм бэ гэдгийг тийм судалгаа байх юм бол сонсмоор байх юм.

Тэгээд хоёрдугаарт бас одоо сая нэг 7.3 тэрбум төгрөгийн авлигын хэрэг гарч ирлээ шүү дээ. Тийм биз. Тэгээд энэ хүний хамаарлыг нь үзэхлээр олон нийтийн сүлжээнээс болохлоор Авлигатай тэмцэх газрын даргынх нь эгчийнх нь орлогч дарга гэдэг нэг хувилбар гарч ирээд байна. Бас нэг хувилбар нь болохоор Улсын Их Хурлын гишүүний сонгуульд ажиллаж байсан хүн юм гэдэг бас ийм хувилбар бас гарч ирээд

байна. Тэгээд маш олон хувилбарууд гарч ирэх байх л даа.

Тэгэхлээр зүгээр санаа нь бол Улсын Их Хурал 76 гишүүн ингээд сонгогдоод явахдаа өөрсдийнхөө ерөнхий менежерүүдийг ихэвчлэн төрийн албанд тавьчихдаг. Түүгээрээ дамжуулаад бас төсөл, хөтөлбөр элдэв төрийн дэмжлэг рүү хамруулчихдаг, эсвэл авлигал, хээл хахуулийн асуудалд холбогдчихдог нь бол түгээмэл шүү дээ. Өнөөдөр би гарахын тулд чи надад тусал, намайг сонгуульд дэмж, миний менежер бол эсвэл санал багцал ч гэдэг юм уу. Ингэж гарч ирээд тэр хүмүүсийгээ дандаа төрийн алба руу явуулдаг. Төрийн албаны тухай хуультай зөрчдөг. Сая бол КОВИД-ын үед гээд КОВИД-ын түр хууль гаргаад төрийн албаны шаардлага хангаагүй маш олон хууль бус томилгоонууд гарсан шүү дээ. Эд нар чинь дандаа л ер нь сонгуультай холбогдсон, сонгуульд ажиллаж байсан хүмүүс юм байна л гэсэн дүгнэлт байна л даа. Тэгэхлээр ийм асуудлыг бодитойгоор яаж хааж өгөх юм, энийг хааж өгөх боломж байна уу гэдэг 2 дахь асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньд-ын Адьшаа гишүүн, хууль санаачлагч асуултад хариулна.

Ш.Адьяа: Доржханд гишүүний асуултад хариулъя. Энэ Хөгжлийн банк, жижиг, дунд үйлдвэрлэл ЖИДҮ сангаас олон улс төрчид өөрөө болон өөрийн хамаарал бүхий компаниудаар зээл авч өнөөдөр нийгэмд ямар асуудал үүсээд байгаа нь тодорхой байгаа. Хэд хэдэн Их Хурлын гишүүд Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангаас зээл авч, өөрөө болон өөрийн хамаарал бүхий компаниудаар дамжуулж авч, тэр нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй болж шүүхээр ял шийтгэсэн ийм судалгаа байгаа.

Ер нь Хөгжлийн банкаар дамжуулж өнөөдөр энэ улс оронд мега том том төслүүдийг хэрэгжүүлэхэд жинхэнэ эзэндээ очдоггүй. Улс төрчид түүний хамааралгүй компаниудаараа дамжуулаад энэ зээлийг авч хулгай луйвар хийдэг ийм схем сүүлийн жилүүдэд газар авсан. Өнөөдөр энэ бол нээлттэй байгаа шүү дээ. Хөгжлийн банкны хэрэг гэж. Одоо 1 дэх өдрөөс Улсын Их Хурлын Түр хороо, хууль хүчний байгууллагатай хамтарч нээлттэй хэлэлцүүлэг хийнэ. Энэ дээр бүр тодорхой болно.

Ер нь бол энэ 30 жилийн хугацаанд ямар өнөөдөр Монголын төрд энэ улс төрчдөд ямар хамгийн муу муухай зүйлийг бий болгосон юм гэхээр өөрөө болон өөрийн хамааралгүй компани руу дамжуулаад ер нь энэ том том төсөл хөтөлбөрүүд, зээлүүд, тендер, төсвийн хөрөнгө мөнгийг завшдаг ийм өндөр том цамхаг болсон шүү дээ. Энийг ард түмэн бүгд мэдэж байгаа. Та бүхэн ч гэсэн энийг мэдэж байгаа. Энэ явдлыг таслан зогсоох нь өнөөдөр Монгол Улсын эрх ашиг, Монгол төрийн үүрэг, төрд итгэх итгэлийн асуудал байгаа юм.

Ийм учраас энийг дэмжсэн гишүүддээ баярлалаа. Тэр төмөр замын нэг нөхөртэй холбоотой асуудал дээр бол тэр хууль хүчний байгууллагаас энэ асуудлыг асуух нь зөв байх. Би бол Доржханд гишүүнтэй нэг адил тийм хэвлэлийн мэдээлэлтэй байна.

Түүнчлэн энэ сонгуульд ажилладаг, улс төрийн нам дамжиж энэ албан тушаалд тавьдаг энэ гинжин холбоо, бид дараа дараагийн улс төрийн намуудын хууль энэ хуулиудаар таслан зогсоох талаар бас анхаарч ажиллах нь өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд, төр барьж байгаа хүмүүсийн үүрэг байгаа. Доржханд гишүүнтэй санал нэг байна.

Г.Занданшатар: Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Үндсэн хуулийн өдрийн баярын мэндийг хүргэе.

Адъяаа гишүүний санаачилсан хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Өмнө нь санаачилсан төсөл дээр ч би бас дэмжсэн байр суурьтай үгээ хэлж байсан.

Ер нь одоо энэ 2006, 7 оноос хойш энэ хэд хэдэн парламентын бүрэн эрхийн хугацаанд энэ асуудлыг тавьж байсан цөөхөн хүмүүсүүдийн нэг нь би байгаа юм. Энэ төрийн албыг төрлийн алба болгодог, энэ төрийн өндөр ажил, албан тушаал, улс төрийн нөлөөллөөр энэ бизнес цаашлах юм бол төрийн баталгаа гаргасан зээл, хууль, төсөл, тендер, концесс, элдвийн юманд оролцож болохгүй таминь.

Энэ Улсын Их Хурлын гишүүн, төрийн өндөр ажил албан тушаал хашиж байгаа улсууд энэ улс төрийн өндөр манлайлалтай байх ёстой гэж ингэж ярьж ирсэн хүмсүүдийн нэг байгаа юм.

Гэтэл энийг үе үеийн парламент, Засгийн газар, Ерөнхий сайд, энэ намын дарга нар бол анхаарч үзэлгүй явсаар өнөөдөртэй золгосон юм л даа.

Харин энэ 2016 оноос Хүрэлсүх, өнөөдрийн Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ нар бол энэ дээр нэлээн санаачилгатай ийм байр суурьтай байгаа. Өнөөдрийн Их Хурал ч гэсэн энэ дээр Занданшатарын даргалж байгаа энэ Их Хурал ч гэсэн нэлээн манлайлалтай ингэж ажиллаж байгаад би баяртай байгаа, талархалтай байгаа.

Засгийн газар, Ерөнхий сайд энэ Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай энэ хууль дээр нэлээн өргөн хүрээнд, өнөөдөр Адъяаа гишүүний

оруулж ирж байгаа энэ хуулийн төсөл бол төрийн баталгаа гаргасан зээл, хуультай холбоотой ямар нэгэн төрийн дэмжлэг, хөнгөлөлттэй нөхцөлтэй ийм боломжуудыг авдаг байдлыг зогсоох тухай ийм хуулийн төсөл гэж би үзэж байгаа.

Үүн дээр бол нэлээн өргөн хүрээнд энэ төрийн албыг төрлийн алба болгодог, өөрийнх нь шууд хамаарал бүхий эхнэр, нөхөр, үр хүүхдүүдийг төрийн албанаас удирдах алба, ажил, албан тушаал төрийн өмчийн компаниудаас чөлөөлөх тухай цаашлах юм бол энэ төрийн худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх тухай мөн Адъяаа гишүүний өргөн барьсан энэ хуулийн үзэл агуулгатай нийцэж байгаа энэ төрийн баталгаа гаргасан зээл, хуулиас авахгүй байх. Ийм нэлээн өргөн хүрээтэй хуулийн төсөл бол боловсруулагдаад Их Хуралд өргөн баригдаж байгаа.

Тийм учраас бол би энэ Засгийн газрын өргөн барьж байгаа энэ хуультай нийцүүлээд, хэлэлцүүлээд хамтад нь явах бололцоо байна уу, үгүй юу гэдгийг би энэ хууль санаачлагчаас асуух гээд байгаа юм.

Нөгөө талаар бол бид нар энэ улс төрийн намын хуулиа шинэчлэх хэрэгтэй гэдэг энэ асуудлыг бид бас олон жил ярьж ирсэн. Өнөөдөр улс төрийн намыг шинэчлэх тухай намын хуулийг шинэчлэхтэй холбоотой асуудал нэлээн хүчтэй яригдаж байна.

Ялангуяа энэ төрийн өндөр ажил, албан тушаал хашиж байгаа улс төрийн нөлөө бүхий хүмүүсүүдийн манлайлал зөв байх, шударга байхтай холбоотой асуудал хүн болгон яриад эхэлж байгаа. Энэ бол их сайшаалтай юм гэж. Би энэ хүрээндээ энэ Монголын нөхцөлд энэ Холбооны Бүгд Найрамдах Герман Улс бусад улс орнуудын жишгээр энэ бизнес төр 2-ыг зааглах хэрэгтэй. Энэ бизнесийн бүлэглэлүүд чинь энэ Улсын Их Хуралд асар их олноороо орж

ирж байна гэж би энэ үе үеийн парламентын мөрөөр.../минут дуусав./

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн, хууль санаачлагч хариулья.

Ш.Адьшаа: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Энэ хулгай луйвартай тэмцэх төрөөс баталгаа гаргасан энэ хөнгөлөлттэй том том зээл, төсөл, хөтөлбөрүүд түүнчлэн энэ тендер, албан тушаалаа ашиглаж хөрөнгөждөг ийм явдлыг таслан зогсоох нь өнөөдөр Монгол төрийн үүрэг, Монгол Улсын Засгийн газрын үүрэг, ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг. Өнөөдөр энэ хуулийн төслөө Засгийн газраас өргөн барьж орж ирэх тэр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэхэд ямар ч татгалзах зүйл байхгүй.

Өнөөдөр Засгийн газрын ч үүрэг байх ёстой, Их Хурлын ч үүрэг байх ёстой. Энэ төрд, нийгэмд бугшсан энэ төрийн өндөр албан тушаалаа ашиглаж, ард түмний боломжийг хулгайлдаг, төсөл, тендер хөтөлбөрүүдийг өөрөө болон өөрийн хамаарал бүхий компаниудаар дамжуулдаг энэ 30 жилийн том хулгай, луйврын цамхгийг бид хамтаараа нураах ёстой. Энэ Засгийн газар ч өнөөдөр ийм асуудал дээр бас их шүүмжлэлтэй, бодлоготой хандаж, тодорхой алхмуудыг хийж байгаад туйлын их бас талархалтай байгаа.

Энэ бол өнөөдөр бас авлигалийн гэмт хэрэг, ашиг сонирхлын гэмт хэрэг, төрд итгэх итгэлийг сайжруулах, ард түмний боломжийг хулгайлдаг энэ явдалтай бас тэмцэж байгаа. Энэ сайн зүйлүүдийг дэмжиж ажиллана. Энэ дээр бол хамтраад хэлэлцээд явахад ямар ч асуудлууд байхгүй гэсэн ийм нэг хариулт өгье.

Түүнчлэн энэ Бат-Эрдэнэ гишүүн бас зөв, зүйтэй саналыг дэвшүүлж байна л даа. Энэ Улс төрийн намуудын хуулийг маш яаралтай оруулж ирэх ёстой. Энэ улс төрийн намаар дамжуулж өнөөдөр олон хулгай луйврыг бий болгодог, ашиг сонирхлын зөрчлийг бий болгодог, аливаа зүйлийг хөрөнгө мөнгөөр шийдэхийг эрмэлздэг ийм юм чинь өнөөдөр газар авч, сүүлд нь том дэлбэрэлтүүд болж байгаа. Энэ дээр өнөөдөр энэ Улсын Их Хурал Улс төрийн намуудын тухай хуулийг энэ намын бүлгүүд яаралтай хэлэлцэж шийдэх нь өнөөдөр Монгол Улсын эрх ашиг байна. Өнөөдөр энэ ард түмэнд итгэх улс төрийн намд итгэх итгэлийн оч энд байна. Ийм учраас энэ Бат-Эрдэнэ гишүүнтэй санал нэг байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Засгийн газраас өргөн мэдүүлэх Нийтийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуультай нэгтгэж өргөн барьсны дараа хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа юм байна. Гишүүд санал хураалт, бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалт явуулсан сая.

Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье.

Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын

томьёоллоор санал хураалтын явуулъя. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, 78.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ Улс төрийн намын тухай хуулийн ажлын хэсэг Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүнээр ахлуулан байгуулагдсан Төрийн байгуулалтын байнгын хорооноос. Одоо энэ хуулийг хаврын чуулганаар хэлэлцэх бэлтгэлийг бүрэн хангах ёстой.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

10.51 цаг

Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны тайланг сонсоно.

Түр хорооны тайланг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 48 дугаар тогтоолоор Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр, асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог 18 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Улсын Их Хурлын 2022 оны 62

дугаар тогтоолоор тус хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ томилогдон ажилласан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалтын дагуу Түр хорооны тогтоолоор Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотойгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулах, санхүү төсвийн асуудлыг судлах, мал эмнэлгийн чиглэлээр болон мал аж ахуй, газар тариалан, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн талаар судлан санал боловсруулах үүрэг бүхий 5 ажлын хэсэг байгуулагдан ажиллаад, ажлын хэсгүүдээс гарсан саналуудыг Түр хороо 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1. Эрх зүй, санхүү, төсвийн асуудлаар:

Эрх зүй санхүү, төсвийн асуудлаар Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд тусгасан 6 хуулийн төсөл болон 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт Түр хорооноос тогтоолоор чиглэл өгсөн.

Мөн дээрх хууль тогтоолын төслүүдээс гадна Төрийн албаны тухай, Малын тоо толгойн албан татварын тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон бусад хуулиудад өөрчлөлт оруулах асуудлыг судлах нь зүйтэй гэж үзлээ.

Ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтын түвшинг ахиулах, маркетинг, өргөтгөлийн өртгийн

сүлжээг хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулан батлуулах саналыг гаргалаа.

Санхүү, төсвийн чиглэлээр хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхой газар зүйн байршилд суурилан төлөвлөгөө төлөвлөхөөр саналаа нэгтгэлээ.

Дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, төсөл, хөтөлбөрүүдийг арилжааны банкнаас олгогдох хөнгөлөлттэй бодлогын зээлийн эх үүсвэрээр хангах боломжийг судлахын зэрэгцээ олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн хөнгөлөлттэй санхүүжилт, дэд бүтцээр дэмжих төсөл, бизнесийн онцлог, зээлийн бүтээгдэхүүнээс хамруулан зээлдэгчийн төлөх хүүг 3-5 хувь байхаар тооцож, Засгийн газрын олгох зээлийн хүүгийн зөрүүг жил бүр эдийн засгийн нөхцөл байдал, Монголбанкны хүүтэй уялдуулан ялгаатай тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Мөн дээрх ажлын хэсгээс зээлийн өсөлтөөс хамааралтай мөнгөний нийлүүлэлтийн валютын ханш, валютын нөөцөд дарамт учруулахгүйгээр санхүүжилтийг үр дүнд, гүйцэтгэлд суурилсан үе шаттайгаар олгох бололцоог бий болгох.

Мөн нийтийн зээлийн эх үүсвэрийн санхүүжилтийн 30-аас доошгүй хувийг хүнсний боловсруулах болон хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг, дунд бизнес эрхлэгчид 10-аас доошгүй хувийг импортыг орлох хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний

үйлдвэрлэлд зориулан олгох саналыг гаргасан болно.

Зээлийн эх үүсвэрийн санхүүжилтийг олгохдоо тэргүүн ээлжид импортын хамаарлын түвшнээр эрэмбэлэн, импортыг орлох хүнсний үйлдвэрүүдийг шинээр болон үйлдвэрлэлийн ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжийг олгоход зээлийн эх үүсвэрийг хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг дэмжихэд ялангуяа хүнсний кластерын тогтолцоог бий болгоход чиглүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

2. Мал аж ахуйн үйлдвэрлэл, амьтны эрүүл мэндийн чиглэлээр:

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд тусгагдсан төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зах зээлийн бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжил төслийн 2 дахь шат, Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай мал аж ахуй зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг яаралтай эхлүүлэх боломжийг бүрдүүлэх. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд ашиглах боломжтой санхүүжилт, зээлийн хүүгийн татаасыг ашиглах боломжийг судлах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн баталгаажсан үүлдэр, омгийн болон эрчимжсэн мал аж ахуйн өсгөн үржүүлж байгаа малын ашиг шимийг хянан баталгаажуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг бүртгэлжүүлж, тогтоосон бүс байршилд үржүүлэх ажлыг эрчимжүүлэх, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар хот, суурин газрын хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлчээр ашиглалт, хамгаалалтын менежментийг сайжруулах, хадлан тэжээл бэлтгэх, тэжээлийн ургамлын үр, бордоо, техник тоног төхөөрөмжийн хангамж, тариалалтыг

нэмэгдүүлэх, малын төрөл, ашиг шимийн чиглэлд тохирсон үйлдвэр, тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хангамжийг сайжруулахад дэмжиж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг тодорхой яамдуудад санал болгож, холбогдох яамдад онцгойлон анхаарах чиглэлийг өглөө.

Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ялангуяа мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүсийг тогтоох, био бэлдмэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, био комбинатын үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, малын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болголоо.

3.Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:

Ажлын хэсгээс төмс, хүнсний ногооны техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор техникийн үнийн дүнгийн 50 хүртэлх хувьд татаас олгох, хөдөө аж ахуйн техник, хүлэмжийн лизингийн тогтолцоог нэвтрүүлэх, мөн хөрсний үржил шимийг хамгаалах, нэгжийн ургац, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо худалдан авахад урамшуулал, татаас олгох, тариалангийн талбайг хашаажуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчид нь тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтарч, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, агро ойжуулалтыг хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөмж, бодлогын дэмжлэг үзүүлэх, мөн таримал ургамлын сорт, сорилтын төв байгуулах, үрийн төрөлжсөн аж ахуйд дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэлийн үр үйлдвэрлэлийн урамшуулал олгох,

үрийн технологийн нөөц бүрдүүлэхэд анхаарч ажиллахыг холбогдох салбарын сайдад чиглэл болгохоор шийдвэрлэлээ.

Газар тариалангийн салбарт хүний нөөцийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, стратеги боловсруулах, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогтой уялдуулан оюутан залуучуудыг тариалангийн үйлдвэрлэл ба ажлын байранд сургах, урт хугацаатай дадлагажуулах, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн санал нь зөвхөн газар тариалангийн салбар биш хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэмжээнд тулгамдаж байгаа асуудал байгаа учир саналыг дэмжих талаар тогтоолд тусгасан болно.

4.Хүнсний боловсруулах үйлдвэрийн чиглэлээр:

Ажлын хэсгээс хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг 2023 оны эхний хагас жилд багтаан байгуулах эрх зүйн орчныг бий болгож, хүрээлэнгийн үйл ажиллагааг эхлүүлэх, мөн бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бүс нутгийн онцлог, нөөц боломжуудад тулгуурласан кластерын зохион байгуулалтаас салбар хоорондын уялдааг хангасан хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Ялангуяа цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хангамж, нийлүүлэлтийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог олон улсын сайн жишигтэй харьцуулан бий болгосноор хүүхдийн хоол, хүнсний чанар аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэж үзсэн болно.

Хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийн бэлэн нөөцийг эргэлтэд оруулах бүс нутгийн онцлогт тохирсон зах зээлд өрсөлдөх чадвартай боловсруулах үйлдвэр,

цехийг хөгжүүлэх, кластрын сүлжээ газар тариалан болон мал эмнэлгийн бүртгэлийн цахим сүлжээтэй уялдуулах, хүнсний борлуулалтыг боловсруулах үйлдвэрээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийг дэмжих нь зүйтэй талаар санал гарч, холбогдох яамдад чиглэл өгөхөөр шийдвэрлэлээ.

Тус Түр хорооноос байгуулагдсан ажлын хэсгүүдэд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг хууль, эрх зүйн орчин, санхүү төсөв, мал аж ахуй, газар тариалан, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр судлан 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 20 гаруй удаа зөвлөлдөх болон санал солилцох уулзалтыг зохион байгуулж, салбарын 50 гаруй мэргэжилтэн, судлаач болон албан хаагчид оролцуулан ажилласан.

Түр хорооны хуралдаанаар хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон Түр хорооны тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хугацаатай уялдуулан хэсэгчлэн баталсан. Энэхүү тогтоолд 4 агуулга бүхий нийт 17 арга хэмжээг тусгасан болно.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг холбогдох Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болголоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн

хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.4-т Түр хороо ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулснаар түүнийг татан буугдсанд тооцно гэж заасны дагуу хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог татан буугдсанд тоолоо.

Болорчулуун сайд, Наянтайн Ганибал гишүүн хэлэлцүүлгээ шууд үдээс хойших хэлэлцүүлгээ танайх бас Үндэсний бодлогын хороо урагшлуулчихъя гэдэг саналыг гаргасан гэж ойлгож байна. Тийм үү? Ингээд дэгийн хуулийн дагуу бол тохиромжтой цагт явуулж болно гэж заасан боломж байгаа. Санал хураалтаар шийдэх үү тээ. Ингээд үргэлжлээд шууд асуудалд орё.

11.02 цаг

Монгол Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Махны экспортын тухай” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун хариулна. Индэрт урьж байна. Хаянгаагийн Болорчулуун сайдыг индэрт урьж байна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулья. Үндсэн хуулийн депутатуудтай, Үндсэн хууль тогтоогчидтой бас уулзах

ажилтай байна. Мөнхбаатар дарга индэрт урьж байна.

Х.Болорчулуун: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр мах, махан бүтээгдэхүүн, экспортын өнөөгийн байдалд цааш авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдад асуулга тавьсан.

Асуулгын хариуг 22 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/3569 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Ганибалд хүргүүлсэн ба өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар тоон мэдээллийг шинэчлэн танилцуулж байна.

Асуулга 1. Монгол Улсын мал сүргийн тоо сүүлийн 5 жилд 3.8 хувиар өсөж, 22 онд 71.1 саяд хүрч жилд дунджаар 20 хувийг буюу 15 сая толгой мал хүнсэнд хэрэглэж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Аймаг орон нутгаас ирүүлсэн судалгаагаар 22-23 онд хүн амын хэрэгцээнд 12.8 сая толгой мал буюу 387 мянган тонн махыг нийлүүлж, нийт мал сүргийн 9.1 буюу 180 мянган тонн мах экспортлох боломжтой байна.

Асуулга 2. Монгол Улс КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс өмнөх 2 жилд 129 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолж байсан бол цар тахлын хязгаарлалт, тээвэр ложистикийн хүндрэл, эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан энэ хэмжээ 45 хувиар огцом буурч, 2020 онд 38.8 мянган тонн, 21 онд 21.8 мянган тонн, 22 онд 43 аж ахуйн нэгж, 10 улсад 16 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон.

Коронавируст халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 6 дугаар сараас эхлэн Бүгд Найрамдах Хятад Ард

Улс Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн импортлохыг хязгаарласан боловч Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрх бүхий байгууллагатай олон удаагийн яриа хэлцэл хийсний дүнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газартай нэмэлт гэрчилгээний загварыг тохирсон.

Үүний үр дүнд 22 оны 11 сарын 15-ны өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын экспорт сэргэж, Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2023 оны эхний сард нойл есөн мянган тонн адууны мах нойл найман мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн, нийт 1.7 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг экспортолсон байна.

Цаашид мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх гуравдагч орны зах зээлд шинээр нэвтрэх зорилгоор ойрх Дорнод болон Зүүн өмнөд Азийн улсын зах зээлийг судалж, халаал аргаар бэлтгэсэн мах экспортлох нөхцөлийг тохирох чиглэлээр ажиллаж байгаа ба 22 онд 5 улсад 3.9 мянган тонн халаал аргаар бэлтгэсэн хонь, ямааны мах экспортлоод байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй 17 үйлдвэрийн үйл ажиллагаа эрүүл ахуй, чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийсэн ба эдгээр үйлдвэрийн үйл ажил ажиллагаа, чанар аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан нь тогтоогдсон.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй 17 үйлдвэрийн үйл ажиллагаа эрүүл ахуй, чанар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй үйлдвэрийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилгоор 100 гаруй мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрт хяналт шалгалт хийж шаардлага хангасан 34 үйлдвэрийн нэрийг Бүгд Найрамдах

Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газарт 21-22 онд хүргүүлсэн.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэг цонхны цэг цахим системд бүртгүүлэх, Монгол Улсын холбогдох байгууллагаар баталгаа гаргуулах, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг цахимаар хүргүүлэх системийг бүрдүүлж, өнөөдрийн байдлаар 9 аж ахуйн нэгж Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагад мах, махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлтээ ирүүлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Монгол Улсын мал сүргийн өсөлт, 2020-23 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг харгалзан 23 оны 10 дугаар сар хүртэл хугацаанд үхрийн махнаас бусад төрлийн махны экспортод тоо хэмжээний хязгаар тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн ба 24 аж ахуйн нэгжид нийт 13000 тонн үхрийн түүхий болон дулааны аргаар боловсруулсан мах экспортлох зөвшөөрлийг бодлогын гэрээ байгуулан олгоод байна.

Асуулга 3.Монгол Улс мах, махан бүтээгдэхүүн экспортлох чиглэлээр дэлхийн 22 улстай хамтран ажиллаж, Засгийн газар хоорондын хэлэлцээр 10, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагын тухай протокол 15, харилцан ойлголцлын санамж бичиг 7, мал эмнэлгийн гэрчилгээ 28, мал эмнэлэг хорио цээрийн нөхцөл 4, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлага 3 тохиролцсон байна.

Асуулга 4.Монгол Улс дэлхийн зах зээлд өрсөлдөхийн тулд Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын газрын амьтны эрүүл мэндийн кодексийн шаардлагыг хангах ёстой. Гэвч Монгол Улсад сүүлийн 10 жилийн хугацаанд олон улсын худалдааны хорио цээртэй шүлхий, хонины цэцэг, бог малын мялзан, үхрийн товруутах өвчин тасралтгүй бүртгэгдсэн ба малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн

экспортлох боломж нөхцөлийг хязгаарлаж байна.

Иймд Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоолоор Монгол Улсын баруун, хангайн, зүүн бүсийн 7 аймгийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүсийг байгуулахаар шийдвэрлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус нийт 7 байгууллага оролцож холбогдох хууль тогтоомжийн дагуу 24 баримт бичгийг давхардсан тоогоор 53 удаа бүрдүүлж, үүнд нийт 316 цаг буюу 13 хоног зарцуулдаг тул төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, шат дамжлагыг бууруулах зорилгоор Хөдөө аж ахуйн биржээр дамжуулж нэг цонхны зарчмыг баримтлан экспортоо цахим системийн хөгжүүлэлтийг эхлүүлээд байна.

Асуулга 5.Монгол Улсын сүүлийн 3 жилд дунджаар 2.3 сая толгой малыг экспортолсон бөгөөд нийт экспортын 90 гаруй хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улс, үлдсэн хувийг Иран, Арабын Нэгдсэн Эмират, Казакстан болон Хонг Конг эзэлж байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэхийн тулд олон улсын худалдааны хорио цээртэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалт, халдваргүйдэл, шилжилт хөдөлгөөний хязгаарлалт, таналтын арга хэмжээг төлөвлөгөөний дагуу тогтмол хэрэгжүүлж байна.

Хоёрт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг малчин өрх бүрээр цахимаар төлөвлөж, гүйцэтгэл, хяналтыг хэрэгжүүлэх. гарал үүсэл ирүүлэн баталгаажсан махыг үйлдвэрт төхөөрч, ул мөрийг нь мөшгөн тогтоох зорилгоор мал эмнэлгийн болон махны үйлдвэрийн үйл

ажиллагааны цахим системийг нэвтрүүлсэн болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүдийн амрыг эрье.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбадоржийн Санчирдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэндбаярын Дондогдорж нар өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Асуулгын хариулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Их Хурлын гишүүд асууж болно. Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу дээр л сөрөг хүчин хариулна. Бусад үед бол Улсын Их Хурлын гишүүд асуулт асуух боломжтой байгаа. Ганибал гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн тэр дундаа мал аж ахуйн бараа бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх энэ тал дээр бол бас маш их л бас хэлж ярьж, асуудлыг бол шийдэхийн төлөө байгаа. Ер нь малчидтай уулзаад явж байхад энэ манай Монгол Улсын малын энэ тоо хэт их болж байгаа, бэлчээрийн даацын асуудал энэ болгоны гарц гаргалгаа бол

ердөө л энэ бараа бүтээгдэхүүнээ, ялангуяа махаа экспортлох энэ асуудал л юм байна лээ. Тэгэхээр энийг зөв голдирлоор оруулаад явуулж чадах юм бол Монгол Улсын энэ хөдөө аж ахуйн салбар бол энэ улс орны эдийн засаг, ард түмний аж амьдралд бол бас туйлын их нэмэр үзүүлэх ийм л том салбар.

Сайдын сая танилцуулгаас ер нь энэ мал аж ахуйн бараа бүтээгдэхүүний экспортын асуудлаар ярьж, хэлж, судалж эхэлсэн цагаас хойш бол Монгол Улсын энэ Хөдөө аж ахуйн яамны энэ мал, махны экспортын асуудал ер нь яг ямар бодлогоор яваад байгаа нь огт ойлгомжгүй байсан. Тэгээд л баахан компаниудад квот өгчихсөн. Энэ Их Хурлын гишүүд бас ярьж байна лээ шүү дээ. Очоод тэр квот өгсөн компанийнх нь очоод л зоорийг нь очоод үзэхээр юу ч байхгүй. Танайх яаж мах экспортолдог юм гэхээр манайх энэ малчдаас малыг нь аваад, ченжүүдээс малыг нь аваад тэгээд гаргадаг юм.

Тэгээд тэр квот дээр нь 2, 3 мянган төгрөг тавьдаг гээд Пүрэвдорж гишүүн Их Хурал дээр яриад байдаг шүү дээ. Тэгээд тэр квот авсан компани мах бэлтгэдэггүй зүгээр л ченж хийдэг, дундаас нь өм цөм ашиг хийдэг ийм л компаниуд явж ирсэн гээд. Ингээд Болорчулуун сайдын саяын танилцуулга, ер нь яамных нь бодлогоос бол энэ малын эрүүл бүс гэдэг юмыг гаргаж байж энэ малын махны экспорт нэмэгдэх юм байна гэж ингэж бас танилцуулагдаж байгаа.

Эндээс ингээд хараад үзэхээр ер нь дэлхий нийтэд улс орныхоо хэмжээнд эрүүл бус болохыг нэг зорьдог. Тухайн орон нутагт эрүүл бүс байгуулдаг, бүр жижигчлээд тухайн аж ахуйн нэгжүүд эрүүл бүс болгоод явдаг ийм л 3 тогтолцоо байдаг юм байна лээ. Тэгэхээр одоо бол манайх эрүүл бүс гэдэг ийм зүйлийг байгуулаад явна гэж байгаа. Баруун аймгуудад 2, 3, зүүн аймгуудад гээд.

Тэгэхээр яг тухайн орон нутагтаа тухайн аж ахуйн нэгж өөрийнхөө хөрөнгө мөнгөөр, тэр хавийн малчидтай, мах бэлтгэгчтэй хамтраад эрүүл бүс болгоод явах ийм ажлууд бас зах зухаасаа хийгдээд эхэлсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр тэр аж ахуйн нэгжүүдээс хэлж байгаа санал юу вэ гэхээр энэ дээр яам тэр зөвшөөрөл, тэр төрийн бодлого дээрээ энийг тусгаад өгчих л юм бол бид Бүгд Найрамдах Хятад Ард Улс саяын энэ 20-иод улстай өөрсдөө гэрээ хэлэлцээрээ хийгээд тэр улсын хорио цээрийн байгууллагуудтай нь хамтарч ажиллаад, стандартад нь нийцүүлээд ингээд явъя гэдэг ийм зүйлийг бас олон аж ахуйн нэгжүүд тавьж байгаа.

Тэгэхээр яг энэ аж ахуйн нэгжүүд энэ яамны энэ эрүүл бүсийн бодлого гаргахдаа энэ аж ахуйн нэгж.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад хэн хариулах уу? Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Идэрбат гишүүнд баярлалаа. Санал хэллээ, 1 асуулт асуулаа. Тэр аж ахуйн нэгжүүд, нутгийн хүн ч гэсэн эрүүл болгохын төлөө олон улсын жишгийн дагуу ажиллаж байна гээд. Жишээлбэл Хэнтий аймагт байгаа тэр чандман талын аж ахуйг хэлж байгаа байх л даа. Тийм. Яг ийм аж ахуйг бол тусгаарлагдсан хамгаалалт бүхий аж ахуй гэж хэлнэ. Яг бүс гэхээр тодорхой 2, 3 сумын нутаг дамжсан тийм хэмжээтэй газрыг бүс гэдэг юм. Олон улсынхаа энэ ойгийн тийм журмаар бол. Тэгэхээр ийм аж ахуйгаа ч гэсэн эрүүл болгоод эрүүлийг нь баталгаажуулаад экспортод гаргах боломжтой гэдгийг бас хэлье.

Ер нь тэгээд бид бол эрүүл бүс байгуулж, махаа эрүүл гэдгийг нь баталгаажуулж, үнэтэй цэнтэй гарах

боломж бүрдэнэ. Мөн сая өөрийн чинь хэлдгээр мал, махыг бол квотгүй болгож, үхрийн махнаас бусдыг бол квотгүй болгож гаргаж байгаа гэдгийг хэлье. Мөн нэг цонхны бодлогоор хөнгөн шуурхай үйлчлэх ажлыг бол эхлүүлээд байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: 2016 онд нийтдээ 80000 тонн мах экспортолж байсан. Тэр нь ихэнх нь дулааны аргаар боловсруулсан мах. Энийг хөлдөөсөн махт шилжүүлэх юм бол 100000 тонн гэсэн үг. Энэ бол социализмын үед хүсээд хүрээгүй ийм экспортын хэмжээ байхгүй юу даа. 100000 тонн экспортолж байхад малын тоо оны эцсээр 620 сая толгой байсан. Тэгэхэд мах багадаж, Монголчууд өсөөгүй. Өнөөдөр энэ 7 сарын төл авсны дараахаар бол 91 сая толгой мал хүрсэн. Гэтэл экспорт нь 10 гаруйхан мянган тонн, 2021 онд бүр 8000 тонн ч билүү тэгж гаргасан байгаа юм.

Тэгээд малын тоо өсөөд байдаг. Экспортын тоо хэмжээ багасаад байдаг. Ийм асуудал болж байгаа. Энэ юунаас болж байгаа вэ гэхлээр улаадаггүй Улаанаас болсон. Квотыг бий болгосон, квот бий болгоод нөгөө хэдхэн компанид 100 гаруй, 110 орчим махны компаниуд байдаг. Тэрний 12-г нь квот олгоод, тэрний 9 нь Хятадын компани, 3 Монгол компани. Тэгээд тэд нар нь нөгөө үлдсэн квотгүй компанийнхаа махыг ченжилж гаргадаг. Тэгээд тэр хүмүүс нь үхрийн мах тутамд 1000 төгрөг буюу 150 килограммтай мал үхэр байлаа гэхэд 150000 төгрөг нөгөө компанидаа тушаадаг. Бог тутамд 20-30 мянган төгрөг нөгөө компанидаа тушаадаг.

Тэгээд тэр компанийн захирлууд тэр мөнгийг кармаанаасаа гаргаж өгдөггүй. Тэр хаанаас авдаг вэ гэхлээр малчны хотноос авч байгаа тэр малын үнийг бууруулах замаар малыг нь худалдаж авдаг байхгүй юу. Тэгээд малчин хүн өнөө жишээ нь 100

бог зарлаа гэхэд 3 сая төгрөгийг нөгөө авлигалын системд төлдөг байхгүй юу даа. Ингэж Монголчуудыг хорлож байсан, 250 мянган малчдыг хорлож байсан ийм үйлдлийг хийж байсан. Тэгээд өнөөдөр энэ квотын энэ асуудлыг яах вэ Болорчулуун сайд засаж байгаа. Үхрээс бусад нь квотыг байхгүй болгосон. Тэгэхдээ үхэр дээр ч гэсэн бас квотыг байхгүй болго.

Яагаад гэвэл 3 сая үхэртэй байж байхдаа үхрийн мах дутагдаагүй байхгүй юу даа. Одоо 6 сая үхэртэй болчихсон байж байгаа. Тийм учраас үхрийн махан дээр квот тогтооно гэдэг бол хүнд суртлыг нь танай яам авч үлдэх сонирхол байна гэсэн үг. Тийм учраас түрүүчийн.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл яах вэ 1 минут нэмж асууж болдог. Тэгэхдээ Пүрэвдорж гишүүний асуултад Болорчулуун сайд хариулья.

Х.Болорчулуун: Пүрэвдорж гишүүн мах өссөн мах, малын тоо өссөн. 90 сая болчихоод байхад экспортын хэмжээ буурсан гээд. Энэ ганцхан тухайн үеийн Улаан сайдаас ч болоод байгаа юм биш л дээ. Энд бол бас сүүлийн 2, 3 жилийн дэлхий нийтийг хамарсан хорио цээрт энэ ханиадны байдал бол гол нөлөөлсөн. Ялангуяа энэ 16 онд бол, 22 онд 16000 тонн болж буурсан нь бол энэ 6 сард Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хамтарсан шалгалт хийж байгаад дулааны аргаар боловсруулж байсан, экспортод гаргаж байсан аж ахуйн нэгжүүдийг зогсоосон байгаа шүү дээ. Ингээд 11 сарын 15 хүртэл энэ дулааны аргаар мах экспортод гараагүй. Ийм учраас махны экспортод бол ийм тоо хэмжээнд шууд нөлөөлсөн гэдгийг бас хэлье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн манай яам бол үндсэндээ үхрээс бусад махны квотыг байхгүй

болгосон. Үхэр бол 5, 6 сая үхэртэй. Хэрвээ квотгүй болгочихвол магадгүй нөгөө Вьетнам шиг үхрээ гаргаад үхрийнх нь мах үнэд орох, дотооддоо үнэтэй үхрийн мах идэх ийм нөхцөл боломж бий болохыг үгүйсгэх аргагүй. Тийм учраас энэ удаагаар бол үхрийн махыг квотоо хэвээр нь үлдээсэн гэдгийг бас хэлье.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн тодруулж асууя. Дэгтэй холбоотой бас Пүрэвдорж гишүүн тодруулж байх шиг байна. Энэ асуулгын хариуд хариулах минут бол 5 минутаас доошгүй байна. Асуулгын асуух хугацаа бол 3 минут байна. Гишүүн шаардлагагүй гэж үзэх юм бол нэмэлт 1 минутаар асуучих дэгтэй байгаа юм шүү. Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэх дээр нөгөө 2016 онд 3200000 хүнтэй байсан. Тэгэхэд 3 сая толгойтой малтай байсан, үхэртэй байсан. Өнөөдөр 6 сая толгой үхэртэй болсон, хүн амын тоо 3300000 болсон байгаа. Тэгэх дээр 3 сая толгой малтай, үхэртэй байж байхдаа үнэ нь хямдхан байсан. Өнөөдөр үнэ нь өссөн байна шүү дээ. Тэгэхлээр энэ юунаас яг энэ бодлогоос бол шалтгаалахгүй байгаа юм. Ер нь бол экспортоос шалтгаалахгүй байгаа.

Тийм учраас энэ ялангуяа Хятад руу гаргаж байгаа экспортлогч компаниудын эрхийг нэмэгдүүлэх тал дээр ялангуяа Болорчулуун сайд идэвхтэй, Хятадын талтай идэвхтэй ажиллаарай. Тэгэх юм бол илүү экспортын хэмжээ нэмэгдэх ийм боломж нь бүрдэнэ. Цөөхөн.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн санал хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Монгол Улс саяхан малаа тоолж дууссан, дүн гарсан. 71.1 сая толгой мал тоолуулсан жилийн эцсээр. Малчид

ажлаа маш сайн хийсэн. Тэд нар энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, хүнсний хангамжид бол гол үүргийг гүйцэтгэж байгаа хүмүүс. Ажлаа маш сайн хийсэн. Харин зориуд тэдний үйлдвэрлэсэн, бий болгосон бараа бүтээгдэхүүн үнэгүй байна. Мах маш бага үнэтэй байна. Дээрээс нь түүхий эд ямар ч үнэгүй байна. Сүүлийн үеийн энэ валютын ханшийн өсөлт, долларын ханшийн өсөлт, юмны үнийн өсөлт инфляцтай харьцуулахад тэдний орж байгаа орлого бол 2 дахин буурсан байна. Төлөг зараад, хонь зараад авдаг хуучин юмныхаа талыг нь л авдаг болсон.

Тэгэхээр энэ тал дээр тэр борлуулалт энэ тал дээр нь ямар бодлого барих юм бэ? Энэ хөдөө аж ахуйн салбарынхаа, гол бүтээгчийнхээ үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах асуудал дээр ямар бодлого цаашдаа баримталж байна? Одоо тэгээд махны экспорт ярьж байна. Махны экспорт бол хуучнаасаа бол муудсан. Одоо бас янз янзын л нөхцөл байгаа байх, одоо сэргэх байх. Маш сайн сэргээж ажилламаар байна. Энэ дээр одоо энэ манайд энэ дутагдаад байгаа энэ худалдааны байгууллагууд явж ажиллах ёстой л доо. Яг гэрээгээ хийж, лоббигоо хийж, борлуулалтаа хийгээд ингээд явах ёстой. Тэгээд энэ дээр нэлээн дутагдал бас гарчхаад байна.

Тэгэхээр энэ ихэдчихээд малчдын бий болгосон энэ махыг борлуулах тал дээр тэр сүүлийн үед яриад байгаа, амьдаар нь ч болсон тодорхой тоонд хүртэл ховортчихоогүй байгаа дээр нь энэ тэр гаргаж л баймаар байна, борлуулж л баймаар байна.

Энэ тал дээр бас энэ Аубакир гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бас бид нар ажиллаад махны үйлдвэрүүд, малчидтай энэ тэртэй уулзаад л явж байгаа. Тэгэхээр энэ дээр бас энэ яам, салбарын яам нь дэмжээд явмаар байна.

Энэ нөөцийн мах гээд нэг юм байгаа юм. Хөдөө аж ахуйн яам бол энэ 2 юмны хайчны яг уулзвар дээр суудаг. Хот, суурин газрын хэрэглэгчдийн махны үнэ өндөр байна гээд нэг талаасаа хүмүүс ярьдаг. Нөгөө талаасаа малчид нь махны үнэ бага байна гээд ярьдаг.

Тэгэхээр гадагшаа маш сайн гаргаад, гадагшаа гарч байгаа тэр компаниудтайгаа, тэр амьдаар нь мал гаргаад байгаа компаниуд энэ тэртэй гэрээ хийгээд тэр өгч байгаа татварыг нь эргүүлээд тэр компенсаци байдлаар юу л даа. Тэр нийслэлийн суурин газрын нөөцийн махныхаа асуудал руу оруулаад тэр үнэ хямдруулах асуудал руу нь оруулахгүй бол нийслэл, суурин газрынхныг хямд мах идүүлэх энэ нэрийдлээр хөдөөгийнхөө гол үйлдвэрлэгчдээ доош нь дараад байна Энэ бол буруу бодлого гэж ингэж бодож байна. Энэ дээр ямар цаашдын бодлого байна гэсэн ийм асуултыг асууя.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад хэн хариулах вэ? Болорчулуун сайд хариулья.

Х.Болорчулуун: Туваан сайд асуулаа. Экспортыг нэмэгдүүлэхийн тулд ямар арга хэмжээ авч байна гэж. Хамгийн түрүүнд бас бид өөрсдийнхөө үйл ажиллагаанаас эхлэх ёстой. Энэ бол яам төдийгүй төрийн байгууллагууд хүнд сурталгүй үйлчлэх ёстой энэ аж ахуйн нэгжүүддээ. Тийм учраас хуучин 300-аад цаг ажиллаж, 13 өдөр хөөцөлдөж байж экспортын зөвшөөрөл авдаг, 6, 7 газраас зөвшөөрөл авдаг байсныг одоо бол нэг цэгийн үйлчилгээ яаман дээрээ төвлөрүүлээд 1-2 хоногт экспортын зөвшөөрөл олгох ийм боломжтой болгох ажлыг хийгээд явж байна. Ингэж гаргаснаараа бол хүнд суртал арилж, махыг экспортлоход бас тодорхой хэмжээнд бол нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Цаашдаа бол бид нар хамгийн гол нь бол энэ дулааны аргаар гэдэг чинь бол Хятад руу яасан л, Хятадын онцлогтой л гаргаж байгаа нөхцөлөө тохирсон хэлбэр шүү дээ. Олон улсын жишгийн дагуу эрүүл бүс байгуулж, түүгээрээ бол малаа эрүүл гэдгийг нь баталгаажуулж үнэтэй, цэнтэй олон улсын жишгээр гаргах ийм бодлогоор ажиллаж байгаа. Энэ хавраас л бүтээн байгуулалтын ажлууд эхэлнэ гэдгийг хэлье.

Нөөцийн махыг асуулаа. Ер нь нөөцийн махыг бол энэ жилээс бол Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам бол бэлдэхгүй гэсэн чиглэлтэй байгаа юм. Тэр хөнгөлөлттэй зээлийг нь нийслэл нь аваад, тэр аж ахуйн нэгжүүд нийслэлийнхээ аж ахуйн нэгжүүдэд өг, угаасаа нийслэлд нь энэ дэлгүүрүүдийн сүлжээ, агуулах зоорь нь байдаг.

Тийм учраас бид бол Хүнс, хөдөө аж ахуй яам үйлдвэрлэлийн яам. Малчдаасаа тэр гарч байгаа үйлдвэрлэлдээ л анхаарахаас биш тэр нийслэлийг махтай байлгах нь нийслэл хотын захирагчийн, нийслэл хотын өөрийнх нь бол үүрэг гэдгийг бас хэлье. Тийм учраас тэр нөөцийн махтай бол цаашдаа бол орооцолдохгүй, ноцолдохгүй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Түүхий эд, арьс шир бол бас ингээд таны хэлдгээр үнэгүйдсэн гэдгийг бас анхааран ажиллаж байгаа. Ойрын хугацаанд, энэ сардаа, ер нь 10 хоногийн дараанаас гэхэд шийдвэр гарна. Бид яамдаас бүх төрлийн арьс, ширийг 2 жилийн хугацаатай экспортод гаргахыг хориглочихсон байсныг чөлөөлөхөөр санал аваад явж байгаа. Ер нь 10 хоногийн дараа бол тогтоол шийдвэр, Засгийн газрын тогтоол шийдвэр гаргана гэсэн ийм бодолтой байна. Тэгэхдээ 2 жилийн хугацаатай. Энэ хооронд бол бид нар үйлдвэрлэлээ бас нэмэгдүүлэх, шинээр бий болгох ёстой.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүн тодруулж асууя. Туваан гишүүн.

Ц.Туваан: Нэмэлтээр энэ махны экспорт ярихаар ерөөсөө параллел нэг ярих ёстой малын эрүүл мэнд. Тэгэхээр малын эрүүл мэнд дээр яг одоо энэ Хөдөө аж ахуйн сайдын багц дээр энэ жил хэдэн төгрөг тавигдсан бэ? Тэр хүнсний хангамж, аюулгүй байдал гээд зэрэгцээд явж байгаа энэ Их Хурлын 36 дугаар тогтоол дээр бас хэдэн төгрөг тавигдсан бэ? Тэгээд энэ хангалттай юу гэсэн ийм асуултыг асууя. Энийг нэг тодруулаад өгөөч.

Дээрээс нь энэ бид нар энэ ажлын хэсгийн хүрээнд хөдөө орон нутгаар махны үйлдвэрүүд үйлдвэрлэгчидтэй уулзаад явахаар энэ хүнсний хангамж, аюулгүй байдлын энэ тогтоол дээр маш их хүлээлт байна. Тэгэхээр энэ дээр тэр бага хувийн хүүтэй зээл олгох асуудал дээр нэлээдгүй ярьж байна. Бид нар бас очиж газар дээр нь үзсэн. Махны үйлдвэрүүд бид нар КОВИД-ын дараа бага хувийн хүүтэй зээл л хэрэгтэй байна гээд байна. Тэгэхээр яг энэ асуудал чинь яг ямар шатандаа явж байна, банкнууд чинь зээлээ олгох эх.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний тодруулгад Болорчулуун сайд хариулья.

Х.Болорчулуун: Хүнсний хангамж аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоол гарсан. Энэ 4 жилийн хугацаанд бол 144 тэрбумыг мал эрүүлжүүлэхэд тавьсан байгаа. 23 ондоо бол 41 тэрбумыг мал эрүүлжүүлэх, энэ дотор бол вакцин, үйлчилгээний зардал бүгд орж байгаа, тавьсан байгаа. Шүлхий өвчинд, шүлхийн дээр гэхэд 10 тэрбум, мялзан өвчин, хонины мялзан өвчин дээр 5 тэрбум, 4 тэрбум, тэгээд бусад өвчнүүд дээр гээд хуваагдаад тавигдсан байгаа гэдгийг бас хэлье.

Ер нь хуучныг бодвол мөнгө төгрөг бол хангалттай тавигдсан. Урьд нь бол бид нар мал эрүүлжүүлэхдээ бол хойш сууж бас

хөрөнгө харамласнаас болж энэ малын шүлхий, товруутах, цэцэг янз бүрийн өвчин.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Болорчулуун сайд гүйцээж харуулъя. Ажлын хэсэг нэмж хариулах юм уу? Ажлын хэсгийн гишүүн өөрсдийнхөө өмнөх дугаарыг өргөөд, нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулна шүү. 83 дугаар микрофоныг өгье ажлын хэсгийн.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр хүнсний хангамжийн энэ 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлд бол энэ жилийн тухайд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн сайдын багц дээр 227.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг урсгал зардал дээр тавьж өгсөн байгаа. Энэ тогтоолыг 2023 онд хэрэгжүүлэхэд нийтдээ 521 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай гэсэн тооцооллыг гаргасан.

Тэгэхдээ энэ бол бүгдээрээ улсын төсвөөс гарах хөрөнгө биш улсын төсөв дээрээс 227 тэрбум төгрөг, гадаадын зээл, дэмжлэг, тусламжийн хүрээнд 190 тэрбум төгрөг, тэгээд зээлийн батлан даалтын сангаар 55 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтаар 25 тэрбум төгрөг гээд. Ингээд нийлээд 521 тэрбум төгрөгийн санхүүжилтгүй ийм хэрэгжихээр төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Үүнээс бид төсөв дээрээ тодорхой хэмжээний хөрөнгөтэй тавигдсан. Зээлийн батлан даалт.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Асуулгын дүгнээд бол үг хэлнэ. Тэгэхдээ бас тодруулаад асуух хэдхэн асуулт байна. Өнөөдөр бас Монголын махны зах зээлийг, гол бодлогыг барьж байгаа бүхий л хүмүүс өнөөдөр энэ танхимд ирчихсэн байгаа учраас.

Ер нь Монгол Улс дэлхийн зах зээл дээр хэрхэн тоглох юм бэ? Өнөөдөр дэлхийн махны тэр бизнесийн эргэлт хэдэн доллар эргэлдэж байгаа талаар та бүхэн бас хэлж өгөөч. Манай экспортод гарч буй мах гарч байгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс, Иран, Вьетнам, Хонг Конг, Казакстан гэсэн мэдээллүүдийг өгсөн байна.

Энэ улсуудад Монголын мах, махан бүтээгдэхүүн гараад яг ямар зориулалтаар хэрэглэгддэг талаар та бүхэн судалсан уу? Энэ шууд дэлгүүртээ гардаг юм уу, нэг эсвэл ресторан, хоолны газруудад очдог юм уу? Эсвэл лаазалсан бүтээгдэхүүн болдог юм уу? Энэ талаар та бүхэн ер нь судалсан уу?

Цаашлаад та хэдийн, та бүхний маань гаргаж өгсөн энэ мэдээлэл дотор Монгол Улсын махны жилийн хэрэгцээ өнгөрсөн жил бол 19, 20, 21 онуудад хэрэглэсэн хэрэглээ хоёрын хооронд зөрүү гараад байгаа юм. Энэ дээр 100000-150000 тонн хүртэл ийм хэмжээний зөрүү гарч байгаа.

Тэгэхээр хэрэглэж болох боломжоосоо 100-150000 төгрөгийн хэрэглээг бид нар дотооддоо хэрэглээд байна гэж байгаа. Энэ тоонууд ер нь зөв үү? Та нар энэ тоонууд дээрээ ер нь ажилласан уу? Ер нь энэ илүү байгаа энэ мах чинь нэг эсвэл ямар нэгэн гаальд мэдүүлэхгүйгээр хилээр гараад байгаа юм уу, эсвэл Монгол Улсад тийм их хэмжээний аялал жуулчлалын жуулчид ирээд Монгол Улсын хэрэглээнээс илүү хэрэглээд байгаа юм уу, нэг эсвэл наад тоон мэдээлэл чинь худлаа юу? Энийгээ та бүхэн бас хэлээд өгөөч.

Мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага дэлхийн улс орнуудад бас судалгаа, шинжилгээ хийж, эрүүл бүс тодорхой хэмжээний бүсүүдийг зарлах,

сертификат олгох ийм үйл ажиллагаанууд хийдэг.

Энэ ажиллагаа ер нь яагаад зогсонги байдалд орчих, яг аль бүсүүдээ эрүүл болгох гэж та бүхэн ажиллаж байна вэ? Заавал тэрийг хүлээхгүйгээр бас боломж байдгийг өнөөдөр бас Замын-Үүд дээр эрүүл бүсийг бий болгоод тухайн улс оронтойгоо харилцаад, мал, амьтан гаргах ийм боломжоор хангагдаж байна. Энэ бодлого маань цааш нь үргэлжлүүлнэ гэдгээ бол сайд хэлж байна. Энэ дээр бас бодсон бодлого чинь юу байна вэ?

Ер нь бид нар Монголын малыг энэ малын гоц халдварт вакцины бай болгодог энэ мафийнхны гараас хэзээ чөлөөлөх юм бэ? Энэ бодлогоо хэзээ зөв болгож, зөв чиглүүлэх вэ гэдгийг бас тодруулаад асуучихъя.

Л.Мөнхбаатар: Асуултад ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа тодорхой хэллээд гишүүний асуултад хариулъя.

Д.Довчинсүрэн: Ганибал гишүүний асуултад хариулъя. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Довчинсүрэн. Эрүүл мэндийн сайдын бол 2017 оны А74 дүгээр тушаалаар бол баталсан 9 хүн амын 1 хүнийг хоногт хэрэглэх мах, махан бүтээгдэхүүний хэмжээг бол үндэслэн тооцоход бол Монгол Улсын нийт хүн амын хүнсний хэрэгцээнд бол нийт жилдээ бол 120 орчим мянган тонн мах, махан бүтээгдэхүүн шаардлагатай гэж үздэг боловч бодит хэрэглээнээсээ үүнээсээ бол 2.8 дахин ихээр бол байгаад байгаа юм. Хэрэглээ бол байгаад байгаа юм. Энэ экспортын энэ мөнгөн дүнгээр нь одоо үзэхэд бол адууны мах гэхэд бол Казахстан Улс руу бол 2300 тонныг бол гаргасан байгаа. Энэ бол мөнгөн дүнгээр бол 7.1 сая доллар гээд. Одоо адууны махыг бодоод

үзэхэд нийт бол 21 сая ам. долларын экспорт бол хийгдсэн байна.

Хонь, ямааны түүхий мах бол 11 сая ам. долларын худалдан авалт хийгдсэн байна. Үхрийн мах бол 463000 ам. долларын бол худалдаа бол хийгдсэн байна.

Дайвар бүтээгдэхүүн бол 205 орчим мянган тонныг бол худалдаа хийгдсэн байна. Энэ дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнүүд дээр нийт бол 17236000 долларын экспортын худалдаа хийгдсэн байна. Нийт махны экспорт бол 50 сая орчим экспортын юу гээд энэ 2022 оны байдлаар бол ийм тоо хэмжээ бол гарсан байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүн хариулт хангалттай юу та? Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монголын махны зах зээлийг сэргээх асуудал бол өнөө төрийн бодлогын хамгийн том асуудал, шийдлүүдийн нэг байгаа. Түүний дотор энэ мах экспортод гаргах, Монголын эко махыг гаднын зах зээлд брэнд болгох асуудал бол төрийн бодлогын хамгийн чухал хэсэг байгаа.

Болорчулуун сайд ирснээс хойш бас их дорвитой ажил хийсэн. Ялангуяа энэ малыг эрүүлжүүлэх, эрүүл бүс байгуулах энэ төрийн бодлогыг чиглүүлж байж, энэ малаа эрүүл болгож байж бид нар дараагийн хүнсний, махны экспортын асуудал шийднэ. Энэ дээр бол эрүүл бүст бас тодорхой бодлого явуулж байгаа.

Түүнчлэн бол энэ КОВИД-ын нөхцөл байдлаар Монгол Улсын бүх экспорт зогссон байхад бас сүүлийн саруудад энэ дулааны аргаар боловсруулсан мах экспортод гаргах түүнчлэн эрүүл бүсийг зохион байгуулж бас Монгол Улсын экспортыг дэмжихэд тодорхой үүрэг

гүйцэтгэсэн сайшаалтай хэрэг байна. Энийг бид дэмжиж цаашдаа Их Хурлын түвшинд ажиллана.

Нэг зүйл асууя. Энэ эртээр бид Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр асуудал ярьж байхад энэ махны тээвэр ложистикийн зам барина, тээвэр хийнэ гэдэг ийм асуудлаар Дэлхийн банкнаас их хэмжээний зээл, тусламж авах асуудал яг орж ирж энэ Байнгын хороон дээр нэлээн их шүүмжлэлтэй хандаж байсан. Ийм асуудал гарахад манай яамнаас ер нь бид ийм санал өгөөгүй, энийг бид тооцоо судалгаагүй ийм асуудлыг бид дэмжих боломжгүй гэж ийм байр суурь илэрхийлж байсан л даа. Тэр байр суурь хэвээрээ байна уу?

Ер нь өнөөдөр ийм асуудлыг, зээл тусламжийг энэ том яамны нэрээр авч байдаг энэ асуудал дээр ямар дүгнэлт хийж байна? Энийгээ өөр зүйлд зарцуулах энэ гаднын зээл, тусламж, экспортыг нэмэгдүүлэх, ялангуяа тэр эрүүл бүс тэр чинь нэмж хэд хэдэн эрүүл бүс бий болгох энэ мөнгийг зарцуулах юм бол бид бол 2 гараа өргөж дэмжинэ шүү дээ.

Гэтэл өнөөдөр махны зам барина, махны тээвэр ложистик гэдэг ийм халхавчин дор Монгол Улсын өрийг нэмэгдүүлэх ийм бодлогыг өөрөө бас шүүмжлэлтэй хандаж байсан. Энэ дээр энэ байр суурь хэвээрээ байгаа юу гэдэг ийм асуултыг асууя.

Л.Мөнхбаатар: Ширнэнбаньдын Ад ышаа гишүүний асуултад Болорчулуун сайд хариулья.

Х.Болорчулуун: Адышаа гишүүн 1 асуулт асуулаа, санал хэллээ. Тэр нэг Дэлхийн банкны 100 сая долларын хөнгөлөлттэй зээл гэж байгаа. Хэдийгээр хүү нь, жилийн хүү нь бага хөнгөлөлттэй боловч яг тэр зарим хэрэгжүүлэх бодлого нь тодорхойгүй байсны улмаас бас энэ дээр

бас миний хувьд, салбарын сайдын хувьд бас үгээ хэлсэн. 100 сая долларын 70 сая доллар нь тэр замын засвар, шинэчлэлт хийгдэнэ. 28 сая доллар нь хөдөө аж ахуйд чиглэсэн байсан.

Гэхдээ манай Хөдөө аж ахуйн яамны саналыг бол тэрэн дээр тусгаагүй. 28 сая доллар гэдэг чинь 90-ээд тэрбум төгрөг шүү. 90 гаран тэрбум төгрөг. Бүр Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороогоор хүртэл хэлэлцэх энэ зээлийн асуудал хэлэлцэгдэх ёстой байсан байхгүй юу. Тэгээд шууд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдэж орж ирсэн.

Ялангуяа тэн дээр бол тээвэр ложистикийн төвийг Өвөрхангай аймагт байгуулах, малчдыг сургах, эмэгтэй малчдын мэдлэгийг дээшлүүлэх гээд ийм бүрхэг бүрхэг яг бодит ажил хийх, үлдэх үлдэц багатай ийм байдлаар төлөвлөсөн байсан.

Тийм учраас бид нар энийг бол Хүнс, хөдөө аж ахуйн яамны бодлоготой уялдуулж энэ мөнгийг зарцуулах ёстой. Энэ эрүүл бүс байгуулах дээр махны үйлдвэрүүд эрүүл бүс тэр яг олон улсын жишгийн махны үйлдвэр байгуулах дээр бид нар бол энийг оруулах нь зүйтэй гэсэн саналыг хэлээд түр Сангийн яамтай яагаад Дэлхийн банкин дээр бас хэлэлцэгдэж байгаад хойшлуулаад байгаа. Тэгээд энэ саналыг маань тусгаж оруулж ирэх байх гэж найдаж байгаа.

Л.Мөнхбаатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал үг хэлнэ.

Н.Ганибал: Асуулгын хариуг сонслоо. Тэгээд дүгнэж хэдэн үг хэлье. Монголын төрийн алдаатай бодлогоос болж шоовдорлогдсон хүмүүс бол Монголын

малчид болж байна. Тэдний өмнө байгаа бизнесийн бүхий л боломжуудыг хааж, малчдыг маань зөвхөн халамжийн бодлогоор хуурч өнөөдрийг хүрлээ. Уг нь мал аж ахуйн салбарыг хамгийн үр өгөөжтэй, ашигтай байлгах бүрэн боломж байгаа. Сонгуульд санал авахад малчид хэрэгтэй болдог болохоор тэдэнд зөвхөн халамж л амладаг. Харин малын бүтээгдэхүүний үнэ цэнтэй болгох боломжуудыг малчдаас маань булаасаар өнөөдрийг хүрлээ.

Мал аж ахуйн салбарын төрийн эдийн засгийн бодлогоос орхигдсон салбар болчихлоо. Эрх баригчид махны үнийг сонгуульд ялах зэвсэг болгон ашиглаж, махны үнийг хүчээр барьж, чөлөөт зах зээлийн жамаар нь явуулахгүй удаж байна. Малчдын орлогын эх үүсвэр бол мал, мах. Эндээс орлогынхоо 70 хувийг олдог. Харамсалтай нь тэр орлогыг нь төрийн буруу бодлогоор боомилсоор өнөөдрийг хүрлээ.

Манай улсад бүх төрлийн барааны үнэ нэмэгдсээр л байна. Харин махны үнийг л барьсаар байгаа. Өнгөрсөн жил гэхэд 1 төлгөөр 3 шуудай цагаан будаа авдаг байсан бол өнөөдөр 1 төлөг ганцхан шуудай цагаан будааны үнэтэй болсон.

Үүнээс харахад малчдын худалдан авах чадвар 3 дахин буурсан нь харагдаж байна. Тэдний 5-хан хувь нь 1000-аас дээш малтай, 60 хувь нь 200-аас доош малтай. Дөнгөж амьжиргаа залгуулж өдийг хүрч амьдарч байна. 300000 малчин төрийн буруу бодлого, популист амлалтын золиос болж буй нь үүнээс харагдаж байна. Монголын хамгийн олон хүн ажилладаг салбар ийм байдалтай байхад яам нь бодитой бодлого танилцуулахгүй хэдэн тоо хэлээд сууж байгаа нь харамсалтай байна.

Малчдын маань халуунд халж, хүйтэнд хөрж бий болгосон малын бүтээгдэхүүнийг үнэ цэнтэй байлгах нь

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үндсэн үүрэг юм. Зуд зурхан болоод хэдэн малаа алдах үед бүх эрсдэлээ малчид өөрсдөө л үүрдэг. Төр хүнд ямар ч хариуцлага үүрдэггүй. Энэ хавар малчдад хатуу хавар болох нь тодорхой болчихсон. Одооноос шууд махныхаа экспортод илүү анхааран ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Дэлхийн зах зээл дээр жилд 31 тэрбум долларын махны худалдаа явагдаж байна. Манай улсын сүүлийн 30 жилийн хугацаанд ганцхан жил л 90 сая долларын мах экспортод гаргасан түүхтэй байдаг. Энэ нь дэлхийн зах зээлийн ердөө 0.3-хан хувь. Ийм том валютын эргэлт явагддаг зах зээлийг бид дотоодын популизмаасаа болоод зориудаар үнийг нь барьж, экспортын орлогоо алдаж байна. Бүгд уул уурхайгаас өөр валют олох боломжгүй гэж боддог байх. Харин бид махаа экспортод гаргаснаар жилд 1 тэрбум ам. долларын орлого олох бүрэн боломжтой.

Гэвч эрх мэдэлтнүүд зөвхөн өөртөө ашигтай байдлаар л шийдвэр гаргаж малчдын эрх ашгийг хөсөр хаясаар ирлээ. Нүүрснээс олох валютаа нэмэгдүүлэхийн тулд БЭТ хүртэл томилдог хэр нь жилд 1 тэрбум доллар олох боломжтой салбараа яагаад шахаж ажиллуулахгүй байгаа юм бэ гэж асуумаар байна. Яагаад бодлогоор дэмжиж, зах зээлийн жамаар нь явуулахгүй байна бэ. Махны экспорт ярихаар шалтгаан тоочдог. Мал нь өвчтэй, хил нь хаалттай, дотоодын махны үнийн зохицуулалтаа хийж чаддаггүй зэрэг түмэн зовлон тоочно.

Ингэж махны экспортыг хийх хүсэлгүй болохоор бэлчээрийн даац нь хэд дахин хэтэрсэн, цөлжилт нүүрлэсэн. Үнэ цэнгүй, таваарлаг бус малтай болох нөхцөлийг бүрдүүлж байгаа. Орлого ашиг муутай энэ салбарт өнөөдөр ажиллах боловсон хүчин ч бас цөөрсөөр байна.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үндсэн зорилго бол хүн ардаа эрүүл хүнсээр хангаж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээс гадна малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үнэ цэнтэй болгож экспортод гаргах замаар малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх явдал. Гэтэл үе үеийн сайд нар нийслэлийн хэрэглэгчдийн социал эсэргүүцлээс айж, махны үнийг тогтвортой барих, нөөцийн махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тухай л ярьсаар байгаад хугацаа нь дуусдаг.

Аль ч цаг үед махны дотоодын хэрэгцээг хангах, экспортод гаргах гэсэн 2 зорилт нь хоорондоо зөрчилддөг. Үүнийг ухаалгаар шийдэх бүрэн боломжтой. Үүнд зөвхөн улс төрчдийн хүсэл зорилго л хэрэгтэй байдаг. Бодлогогүй төрийн болчимгүй алхмууд мал аж ахуйн салбарыг өндийлгөхгүй байгаа болохоор л өнөөдөр би энэ асуулгыг тавьсан юм. Мал аж ахуйн гол бүтээгдэхүүн болох махыг үнэ цэнтэй байлгахын тулд экспортыг хорих биш дэмжих ёстой. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибалаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

11.48 цаг

Одоо баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг сонсьё.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан:

Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн

байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа юу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Холбогдуулсан, боловсруулсан:

Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан:

Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй

байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Өрийн удирдлагын тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болгох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийг найруулга сонсонд тооцлоо.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй

байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

11.58 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*

